



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Жаргалант сумын 3 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2024/185/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Эвиденсе аудит ХХК-ийн захирал: С.Бадамгарав

Утас: 99057121

Цахим хаяг: info@evidenceaudit.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Т.Болортуяа

Утас: 99017537

Цахим хаяг: Bolortuya@evidenceaudit.mn

Аудиторын туслах: М.Отгонням

Утас: 85222519

Цахим хаяг: Otgonnyam@evidenceaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН 3 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Л.ЧУЛУУНБААТАР ТАНАА

2024.02.24 № 11/28
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын 3 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Жаргалант сумын 3 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сургалтын тоног төхөөрөмжийн хангалт хуваариллыг хийх багийг захирлын тушаалаар томилж 204-р ангийг "Цахим кабинет" болгов. 30 ширхэг таблет, ухаалаг дэлгэц, нөүтбүүк 1 ширхэг, скайнер 1 ширхэг, принтер 1 ширхэг авсан. Орон нутаг хөгжүүлэх сангаас авсан санхүүжилт, хэрэгжилт байхгүй.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй, нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

БШУ-ны яамнаас олгож буй бичиг хэргийн зардлыг олгох, үнийн судалгаа хийх багийг захирлын тушаалаар томилж жилд 2 удаа бичиг хэргийн зардал олгосон. Сургуулийнхаа 59 багш модуль сургалтанд хамруулсан. Багш ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх БОЭТ, Ач заяа эмнэлэгтэй хамтран эрүүл мэндийн иж бүрэн нэгдсэн үзлэгт хамрагдсан. Мөнх цохилохуй эмнэлэгтэй хамтран ЭМД сангаас хөнгөлөлттэй уламжлалт бариа засал, усан эмчилгээ, зодэсийн шинжилгээ, цусны дэлгэрэнгүй, Д витаминь шинжилгээнүүдийг авч ажилласан. Хамтын сангийн сар бүрийн хуримтлал, ҮЭ-ийн гишүүний хуримтлалаар ажилтан албан хаагчдад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж ажилладаг.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын 25 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг тооцон тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Х.БОЛДБААТАР

Нэг . Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мян. төгрөг/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	148,653.56	231,252.92
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,358,357.59	1,370,178.93
	Нийт хөрөнгийн дүн	1,507,011.14	1,601,431.85
	Нийт өр төлбөрийн дүн	-	1,540.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,507,011.14	1,599,891.85
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,507,011.14	1,601,431.85
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,073,764.68	2,706,500.27
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,083,530.84	2,613,619.56
	Үйл ажиллагааны үр дүн	(9,766.16)	92,880.71
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(9,766.16)	92,880.71
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,507,011.14	1,507,011.14
	Тайлант оны үр дүн	-	92,880.71
	Эцсийн үлдэгдэл	1,507,011.14	1,599,891.85
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,026,850.00	2,575,151.05
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,014,559.20	2,490,189.04
	Үйл ажиллагааны ЦМГ	12,290.80	84,962.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	12,290.80	84,962.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	12,290.80
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,290.80	97,252.80
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,586,807.50	2,490,853.46
	Урсгал зардал	2,586,807.50	2,490,853.46
	Хөрөнгийн зардал	-	-
	Эргэж төлөгдөх зээл	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,586,807.50	2,575,815.46
	Улсын төсвөөс санхүүжих	2,253,427.90	2,253,427.90
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	312,510.60	312,510.01
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	20,869.00	9,877.55
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих /бусад/	-	-
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	-
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	12,290.80
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	97,252.80

Хоёр . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар алдаа зарчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1			1			
	Нийт	1	1			1			